

Ю. Цэрмаа

**БНХАУ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧДӨӨС НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ
БАЙГУУЛЛАГАД ЯВУУЛЖ БАЙГАА ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах чухал үүрэг бүхий байгууллага болох Нэгдсэн Үндэстний Байгууллагад хятадын ард түмнийг төлөөлөх эрх байхгүй Чан Кайшийн дэглэмийн төлөөлөгчид 22 жилийн турш суусан билээ. Тэгэхэд БНМАУ социалист бусад орны хамт БНХАУ-ын хууль ёсны эрхийг НҮБ-д сэргээх, Чан Кайшийн төлөөлөгчдийг энэ байгууллагаас зайлуулахын төлөө идэвхтэй тэмцэл явуулж байв. Социалист орнуудын энэхүү тууштай зарчимч байр суурь нь юуны өмнө хятадын ард түмний ашиг сонирхол, НҮБ-ын түгээмэл чанараас урган гарч байгаа юм. Олон улсын энэхүү түгээмэл байгууллагад хятадын ард түмнийг зөвхөн БНХАУ-ын засгийн газар төлөөлөх ёстой гэж БНМАУ үзэж ирсэн ба НҮБ-ыг үндэслэн байгуулагчийн нэг, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн байх ёстой БНХАУ НҮБ-д эрхээ сэргээснээр империализмын эсрэг фронтыг өргөжүүлэн бэхжүүлэх, түрэмгийлэл, колоничлолын эсрэг, энх тайван, олон улсын хамтын ажиллагааны төлөө тэмцэлд энэ байгууллагын үйл ажиллагааг улам бүр бүтээлтэй болгоход тус нэмэр болно гэж найдаж байсан юм.

x x x

1971 оны аравдугаар сарын 25-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXVI чуулган НҮБ-д БНХАУ-ын эрхийг даруй сэргээн, Чан Кайшийн дэглэмийн төлөөлөгчдийг энэ байгууллагаас хөөн зайлуулах тухай 26 орны оруулсан тогтоолыг дийлэнх олонхийн саналаар батлав. Энэ тогтоолыг 76 улс, түүний дотор социалист бүх орон, Ази, Африкийн дийлэнх орнууд дэмжсэн бөгөөд АНУ, Япон, Австрали, ӨАБНУ зэрэг 35 улс эсрэг санал өгч, 17 улс түдгэлзэв. Ийнхүү Чан Кайшийн дэглэмийн төлөөлөгчид НҮБ-аас хөөгдөж, БНХАУ-ын эрхийг сэргээсэн юм. БНХАУ хууль ёсныхоо эрхийг НҮБ-д сэргээсэнтэй холбогдуулан баяр хүргэж хэлсэн үгэндээ БНМАУ-ын төлөөлөгч «БНХАУ энхийг эрхэмлэгч улс гүрнүүдтэй нягт хамтран ажиллаж энх тайван, олон улсын хамтын ажиллагааны хэрэглүүр болсон НҮБ-ыг бэхжүүлэх болон өнөө үеийн олон улсын амьдралын амин чухал асуудлуудыг нааштайгаар шийдвэрлэх хэрэгт хувь нэмрээ оруулна»¹ гэдэгт найдаж байгаагаа илэрхийлсэн билээ.

Гэвч хятадын удирдагчид энэ чухал байгууллагад БНХАУ-ын хууль ёсны эрхийг сэргээхийн төлөө 22 жил тэмцэж ирсэн улс гүрнүүдийн итгэл найдварыг хөсөрдүүлсэн юм. Учир нь энэ үед хятадын эрх баригчид социализмын гадаад бодлогын зарчмуудаас урван тэрслэж, олон улсын харилцааны үндсэн чухал асуудлаар сөрөг байр суурь баримтлах замд орсон байлаа. БНХАУ нь НҮБ-д эрхээ сэргээсэн анхны өдрөөсөө эхлэн энэ байгууллагыг их гүрний дээрэнгүй жанжлах бодлогоо хэрэгжүүлэх талбар болгон ашиглах гэсэн нь тэдний үйл ажиллагаанаас тодорхой харагдаж байна. Хятадын төлөөлөгчид НҮБ-ын индрийг ашиглан юуны

¹ А/РҮ. 1973. р, 73.

өмнө ЗХУ болон социалист бусад орны энх тайванч гадаад бодлогыг гүтгэн гуйвуулах, олон улсын уур амьсгалыг эрүүлжүүлэхэд чиглэсэн бүхий л саналыг эсэргүүцэх, зэвсэг хураах талаар аливаа ахицыг саатуулахад үйл ажиллагаагаа чиглүүлсэн юм.

Хятадын Гадаад явдлын яамны орлогч сайд тэргүүтэй төлөөлөгчид 1971 оны арван нэгдүгээр сард Нью-Йорк хотноо хүрэлцэн ирж Ерөнхий Ассамблейн чуулган дээр анхныхаа үгийг хэлж, олон улсын харилцааны гол гол асуудлаар хятадын эрх баригчдын баримталж байгаа бодлогыг илэрхийлсэн билээ.

Хятадын төлөөлөгч орчин үеийн олон улсын байдлыг үнэлж ярихдаа «нэг юм уу хоёр их гүрнээс явуулж буй хүч түрэн жанжлах бодлогыг эсэргүүцэх, өөрсдийн хэргийг өөрсдөө шийдвэрлэх эрхээ эдлэхийн төлөө тэмцэл дунд буюу жижиг хэмжээний орнууд улам олноороо нягтарч байна» гэв. Ийнхүү ЗХУ-ыг капиталист ертөнцийн зонхилох гүрэн АНУ-тай адилтган нэг зиндаанд тавьж, тэгснээрээ ЗХУ-ын эсрэг дунд, жижиг гүрнүүдийг тухирах гэсэн оролдлогоо хийв. Хятад НҮБ-ын хүрээнд ЗХУ болон социалист бусад оронтой хамтран ажиллах нь байтугай харин ч тэдний эсрэг хамаг үйл ажиллагаагаа чиглүүлсэн юм. Мөн «Хятад гурав дахь ертөнцөд хамаарагдана» гэж НҮБ-ын индрээс шууд зарласан нь Хятад дэлхийн социалист системээс тасран салсныг илэрхий харуулав.

Хятадын, төлөөлөгчид «хоёр хэт их гүрний өрсөлдөөн» дэлхийн дайнд зайлшгүй хүргэх мэтээр номлон, ЗХУ, АНУ-ыг хооронд нь мөргөлдүүлэхийг тухиран дуудаж байдаг юм. 1974 онд хуралдсан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн VI тусгай чуулган дээр Дэн Сяопин «хоёр хэт их гүрэн дэлхийн шинэ дайны голомт» болж байна гэсэн бол 1978 онд Зэвсэг хураах асуудлаар болсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн X тусгай чуулган дээр хятадын төлөөлөгчдийн тэргүүн Хуан Хуа «Тэмцэл нь өсөхийн хирээр тэд (ЗХУ, АНУ) зайлшгүй мөргөлдөнө» гэв.

Түүгээр ч барахгүй хятадын төлөөлөгчид ЗХУ-д «социал-империализм» гэдэг хаяг зүүж, ЗХУ-ыг гүтгэх замаар түүний нэр хүндийг гутаах, энх тайванч гадаад бодлогын нь зорилгыг мушгин гуйвуулахад бүхий л үйл ажиллагаагаа чиглүүлж байна. Хятадын төлөөлөгчдийн тэргүүн Хуан Хуа НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганы ерөнхий шүүмжлэлд хэлсэн үгэндээ ЗХУ-ыг ичгүүр сонжуургүй гүтгээд түүний эсрэг «өргөн фронтоор» тэмцэхийг уриалж байв.

Хятадын төлөөлөгчид Маогийн «гурван ертөнцийн онол» гэгчийг гадаад бодлогодоо хатуу баримтлахаа илэрхийлж, энэ харгис онолыг НҮБ-ын индэр дээрээс өргөн сурталчилж байна. Энэ онол ямар ч үндэсгүй болох нь НҮБ-ын практик үйл ажиллагаа болон олон улсын харилцаанд болж байгаа үйл явдлын явцаар нотлогдсон билээ. 1977 оны арван хоёрдугаар сард хуралдсан МАХН-ын Төв Хорооны III бүгд хурал дээр МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ю. Цэдэнбал хэлэхдээ «Хятадын эрх баригчид БНХАУ-ын гадаад бодлогын онолын үндэс болох учиртай «гурван ертөнц» гэгч маоист үзлийг зэвсгээ болгож авчээ. Бээжингийн эрх баригчид энэ үзлийг иш үндэс болгож, юуны өмнө харгис хүчинд түшиглэн бүх улс орон, хөдөлгөөнийг тэдгээрийн нийгмийн байгуулал, улс төрийн зорилгыг үл харгалзан оролцуулж Хятадын захирамжийн дор зөвлөлтийн эсрэг өргөн фронт байгуулахыг уриалж байна»² гэсэн билээ.

Хятадын төлөөлөгчид энх тайвныг бэхжүүлэх, олон улсын түгшүүртэй байдлыг намжаах явдлыг НҮБ-ын хүрээнд улайран эсэргүүцэж, цөмийн

¹А/S—10/pv- 7. р. 57.

²«Намын амьдрал», 1978 оны № 1, 7-р тал.

зэвсэг хураах, дайны аюулыг арилгахад чиглэсэн хүч чармайлтыг элдвээр эсэргүүцэж байна. 1970 онд ЗХУ-ын санаачлагаар олон улсын аюулгүй байдлыг бэхжүүлэх тухай Тунхаглалыг хэрэгжүүлэх талаар цаашид үр бүтээлтэй арга хэмжээ авахыг бүх улс оронд уриалсан тогтоолыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXVI чуулганаар батлахад хятадын төлөөлөгч улайран зэсэргүүцэж байв. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXXII чуулган дээр хятадын төлөөлөгчид хэлсэн үгэндээ «.. намжмал байдлын үйл явцыг эргэлт буцалтгүй болгоно гэдэг бол хоосон хуурамч яриа», «энх тайванд итгэж найдах хэрэггүй. Шинэ дайны аюул мэдэгдэхүйц ихсэж байгаа тул бүх улс үндэстэн түүнд бэлтгэлтэй, байх хэрэгтэй» хэмээн улс түмний дунд энх тайванд үл итгэх үзэл санаа түгээх, бусдыг хардаж сэрдэх явдлыг хүчтэй болгоход чиглэсэн үг хэлж байв.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн ээлжит чуулганд хэлэлцэж байгаа олон асуудлын дотроос зэвсэг хураах асуудал нийт төлөөлөгчдийн анхаарлын төвд байдаг билээ. Харин хятадын төлөөлөгчдийн НҮБ-д хэлсэн анхны үгээс үзэхэд тэд зэвсэг хураахад чиглэсэн нааштай бүхнийг улангасан эсэргүүцэх нь тодорхой байв. «Цөмийн зэвсгийг хураах талаар цөмийн зэвсэгтэй орнуудын хэлэлцээ гэгчид Хятад хэзээ ч оролцохгүй» гэж хятадын төлөөлөгч НҮБ-ын индрээс мэдэгдсэн нь хэрэг дээрээ дэлхийд жанжлалаа тогтоохын төлөө зэвсгээр хөөцөлдөхөө нотолж, цөмийн зэвсгийн өрсөлдөөнд бусдыг уриалан дуудсан юм.

Бүх улсын төлөөлөгчид хуран цугларч, зэвсэг хураах чухал асуудлыг хэлэлцэж зохих арга хэмжээ авч болох Дэлхий дахины бага хурлыг зарлан хуралдуулах тухай 1971 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXVI чуулганд ЗХУ-ын оруулсан саналыг НҮБ-ын гишүүн орнуудын дийлэнх нь сайшаан дэмжив. Гэтэл хятадын төлөөлөгч эсэргүүцэж, «ийм бага хурал хийгээгүй нь дээр» гээд зөвлөлтийн саналын нандин зорилгыг гүтгэн дайрч, ЗХУ-ын тогтоолын төслөөр санал хураахгүй өнгөрөхийг Ассамблейд шаардаад, хэрэв санал хураахад хүрвэл хятадын төлөөлөгч оролцохгүй гэж сүржигнэсэн юм.

Мөн XXVI чуулганаас цөмийн зэвсгийн бүхий л туршилтыг хориглохыг уриалсан тогтоол батлахад хятадын төлөөлөгч эсрэг санал өгөөд зогсоогүй «хятад цөмийн зэвсгийн туршилтыг цаашид ч хийх болно» гэж мэдэгджээ. Чингээд Хятад НҮБ-д анхныхаа үгийг хэлснээс гуравхан өдрийн дараа цөмийн дэлбэрэлт хийж амаар зарлаж байснаа ажил хэрэг дээрээ батлан харуулсан болно.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXVII чуулганаар хэлэлцсэн асуудлуудын дотроос нийт төлөөлөгчдийн анхаарлыг татсан чухал асуудал нь олон улсын харилцаанд хүч хэрэглэхээс татгалзах, цөмийн зэвсэг хэрэглэхийг бүрмөсөн хориглох тухай ЗХУ-ын оруулсан тогтоолын төсөл байв. Бүх хүн төрөлхтний амин чухал ашиг сонирхолд нийцсэн зөвлөлтийн энэхүү санаачлагыг НҮБ-ын гишүүн дийлэнх улс орнууд дэмжин сайшааж байхад хятадын төлөөлөгч «энэ тогтоолыг хатуу чанд эсэргүүцэж байна» гэж мэдэгдээд Өмнөд Африк болон бусад харгис үзэлтний хамт түүний эсрэг санал өгч байв, Мөн хятадын төлөөлөгчдийн тэргүүн XXVII чуулганы индэр дээрээс «Олон тооны дунд, жижиг орны хувьд гэвэл тэдний өмнө тулгарч байгаа гол асуудал нь зэвсэг хураах огт биш, харин биеэ даасан батлан хамгаалах чадвараа бэхжүүлэх явдал мөн» гэж улс гүрнүүдэд зэвсэглэхийг уриалж байлаа.

1973 онд хуралдсан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXVIII чуулганаар ЗХУ-ын санаачилсан Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүдийн цэргийн зардлыг 10 хувиар хорогдуулж, хэмнэсэн хэсгээр хөгжиж байгаа орнуудад тусламж үзүүлэх тухай асуудал хэлэлцэв. Энэ саналыг хэрэгжүүлэх нь зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг зогсооход чухал хувь нэмэр болох нь мэдээжийн хэрэг билээ. Гэтэл хятадын төлөөлөгч «Цэргийн

зардлыг яаж тооцоолох юм бэ? Зөвхөн үүнийг шийдвэрлэхийн тулд комисс байгуулах шаардлагатай бөгөөд энэ комисс олон жил ажиллах хэрэгтэй болно. Цэргийн зардлыг хорогдуулж болно гэж үү дээ? Үүнийг хэн ч үзээгүй шүү дээ. Бидний бодлоор бол энэ хоосон үгээ даруйхан буцааж авсан нь дээр» гэж цэргийн төсөв зардлыг хорогдуулахыг эсэргүүцэв.

ЗХУ-ын санаачлагаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXXII чуулганд хэлэлцүүлэхээр оруулсан «Олон улсын намжмал байдлыг гүнзгийрүүлэн бэхжүүлэх тухай тунхаглалын төсөл, цөмийн дайны аюулыг сэрэмжлэн зайлуулах тухай тогтоолын төслийг эсэргүүцээд, энэхүү амин чухал санаачлагыг «давхар мэх»¹ гэж дайрав.

1978 онд хуралдсан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXXIII чуулганд хэлэлцүүлэхээр оруулсан цөмийн зэвсэггүй орнуудын аюулгүй байдлын баталгааг бэхжүүлэх тухай ЗХУ-ын шинэ санаачлагыг «Цөмийн зэвсэггүй орнуудын аюулгүй байдлын баталгаа гэсэн нэрээр олон тооны дунд, жижиг орнуудыг хөл гараар нь хэлхэж, тэдний өөрсдийгөө хамгаалах бололцоог үгүйсгэхэд чиглэж байгаа юм»² гэж улайн цайм эсэргүүцээд, уг асуудлаар баталсан тогтоолд эсрэг санал өгөв.

ЗХУ, АНУ-ын хооронд явагдаж байсан стратегийн давшилтын зэвсэглэлийг хязгаарлах тухай хэлэлцээг «ийм гэрээ гэгч нь тэдний хооронд стратегийн зэвсэглэлээр хөөцөлдөхөд түлхэц үзүүлэх ба тус дөхөм болох гэсэнтэй ижил утгатай үг юм. Энэ хэлэлцээний явцад байгуулсан гэрээ бүр стратегийн зэвсэглэлээр хөөцөлдөх шинэ үе шат болно»³ гэж хятадын төлөөлөгч ямар ч нотолгоогүйгээр дайран довтолж байв.

Хятадын төлөөлөгчид НҮБ-д хэлэлцэж байгаа улс төр, олон улсын эдийн засаг, хууль зүй, НҮБ-ын санхүү төсвийн асуудлаар сөрөг байр суурь баримталж мөн л ЗХУ-ыг гүтгэн дайрахад бүх үйл ажиллагаагаа чиглүүлж байна.

Тэд Ойрхи Дорнодын асуудлыг шударгаар шийдвэрлэхэд чиглэсэн аливаа алхмыг саатуулахыг оролдож байгаа билээ. Өөрсдийгөө арабын ард түмний дотны холбоотон гэж аман дээрээ сүржигнэн зарлавч, хэрэг дээрээ асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн ямар нэг санал дэвшүүлээгүйгээр барахгүй, асуудлын мөн чанарыг мушгин гуйвуулж, Ойрхи Дорнодын асуудлын гол гогцоо нь «хэт их гүрнүүдээр (ЗХУ, АНУ) дэмжүүлсэн сионист Израиль нь Палестины болон бусад арабын ард түмний эсрэг хийсэн түрэмгийлэлд оршино» гэж байв. Тэд Израилийн түрэмгийллийг дэмжсэн мэтээр ЗХУ-ыг эрээ цээргүй гүтгэж байв. Ойрхи Дорнодын асуудлаар ЗХУ-ын баримталж байгаа тууштай зарчимч бодлого араб ард түмнүүдийн гүн талархлыг хүлээж байдгийг бүх нийтээр мэдэх билээ.

Ойрхи Дорнодын асуудлаар хятадын удирдагчдын баримталж байгаа хорт бодлогын мөн чанар бүгдэд тодорхой юм. 1972 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXVII чуулганд Ойрхи Дорнодын асуудлаар хөгжиж байгаа орнуудын оруулж батлуулсан тогтоолыг дэмжихээс татгалзсан юм. Эзлэн түрэмгийлэх бодлогоо үргэлжлүүлж байгаа Израилийг буруушааж, Израильд аливаа тусламж үзүүлэх явдлыг хориглохыг шаардсан энэхүү тогтоолоор санал хураахад түдгэлзэж, сионист түрэмгийлэгчдийг өөгшүүлэн дэмжигчидтэй эвсэн нэгдсэнээ харуулсан юм. 1973 оны долоодугаар сард Ойрхи Дорнодын асуудлыг Аюулгүйн Зөвлөлд хэлэлцэхэд эвсэлд нэгдээгүй 8 орны оруулсан тогтоолоор санал хураахад оролцоогүй бөгөөд мөн орны аравдугаар сард Ойрхи Дорнодод гал зогсоох

¹ А/С. 1/32. РҮ 47. р. 14—15.

² А/33/РҮ. 13. р. 101.

³ А/С. 1/32 РҮ. 10. р. 23.

тухай Аюулгүйн Зөвлөлд оруулсан тогтоолыг «ов мэх», «цаасны тасархай» гэж нэрлэж байв.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXX чуулган дээр 1967 онд эзлэгдсэн арабын нутаг дэвсгэрээс Израилийн цэргийг гаргах, Палестины араб ард түмний хууль ёсны эрх, тухайлбал, төр улсаа байгуулах эрхийг нь хангах заалт бүхий тогтоолыг социалист орнууд, эвсэлд нэгдээгүй 84 улс, өрнөдийн нилээд орон дэмжсэн юм. Гэтэл энэ тогтоолоор санал хураахад хятад мөн л оролцсонгүй.

Киприйн асуудлаар НҮБ-д хэлсэн үгүүддээ «хоёр хэт их гүрний өрсөлдөөн болон тэднээс Киприйн дотоод хэрэгт оролцож байгаа явдал сүүлийн жилүүдэд асуудал ноцтой болж, шийдэгдэхгүй байгаагийн үндсэн шалтгаан болж байгаа» мэтээр тайлбарлаж, мөн л ЗХУ-ын энх тайванч бодлогыг гүтгэж байв.

Хятадын удирдагчид өөрсдийгөө үндэсний эрх чөлөөний тэмцлийг тууштай дэмжиж, колоничлол, арьсны үзлийн дарлалд байгаа улс түмний талд тууштай зогсдог гэж НҮБ-ын индэр дээрээс сүржин зарладаг боловч, хэрэг дээрээ ичгүүр сонжуургүй бодлого баримталж байдаг билээ. Зүүн Пакистаны ард түмний чөлөөлөх хөдөлгөөнийг Пакистаны цэргийн дэглэм хэрцгийлэн дарах оролдлого хийснээс үүссэн Энэтхэг, Пакистаны мөргөлдөөний асуудлыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, Ерөнхий Ассамблейн хэлэлцэх үед хятадын төлөөлөгч Пакистаны харгислалын талд байж, Бангладешийн 75 сая ард түмний хувь заяаг шийдвэрлэх чухал асуудал дээр америкийн империализмтай гар гараасаа барилцан зогссон юм. Хятадын төлөөлөгч шинэ дутам үүссэн Бүгд Найрамдах Бангладеш Улсыг дайрч давшилж, НҮБ-ын гишүүнээр элсэхэд нь элдвээр саад тотгор тавьж байв.

Ангол улсад болсон үйл явдлын үеэр Хятад цэргийн зөвлөхүүдээ илгээж, АНУ-ын Тагнуулын төв газар болон арьсны үзэлтнүүдээр дэмжүүлж байсан ФНЛА-гийн хагалан бутаргагч этгээдүүдэд зэвсэг нийлүүлж өөгшүүлэн дэмжиж байсан хийгээд Бүгд Найрамдах Ангол Ард Улсыг НҮБ -д элсүүлэх тухай тогтоолоор санал хураахад оролцоогүй зэрэг нь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний талаар хятадын баримталж байгаа бодлогын үнэнхүү нүүр царайг дэлхий дахинаа илчлэн харуулсан юм.

Олон улсын эдийн засаг, хөгжлийн асуудлаар НҮБ-д хэлсэн үгүүддээ «хоёр хэт их гүрний жанжлан ноёрхох, сүрдүүлэх, тонон дээрэмдэх бодлогоос болж, олон улсын эдийн засгийн шинэ журам тогтоох асуудал саатаж, гуравдахь ертөнцийн орнуудын эдийн засаг зогсолт, хямралын байдлаасаа гарч чадахгүй байгаа» мэтээр номлож байна. «Үй олон бага, дунд орнуудаас эдийн засгаа хөгжүүлэхээр тавьж байгаа зорилтыг зөвхөн өөрийн хүчинд тулгуурлан хоёр хэт их гүрний эсрэг тэмцлээ улам хүчтэй болгох үндсэн дээр л шийдвэрлэж болно» гэж номчирхон ярьж байна.

ЗХУ болон социалист бусад орноос хөгжиж байгаа орнуудад үзүүлж байгаа эдийн засаг, санхүүгийн их тусламж, тэднээс хөгжиж байгаа орнуудтай тогтоосон эдийн засгийн тэгш харилцааг гүтгэн гүжирдэж, хөгжиж байгаа орнуудыг социалист орнуудаас хөндийрүүлэхийг оролдож байна. Түүнчлэн ЭЗХТЗ, олон улсын социалист хөдөлмөрийн хуваарь, социалист интеграцийн бодлогыг дайран довтолж, «энэ нь шулан мөлжигч, хяналтандаа барих социал империализмын систем» мэтээр гүтгэж байна.

ЗХУ-ын саналаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXXI чуулганы хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд оруулсан олон улсын харилцаанд хүч үл хэрэглэх тухай дэлхий дахины гэрээ байгуулах асуудлыг хууль зүйн асуудал эрхлэдэг зургаадугаар хороонд авч хэлэлцэхэд хятадын төлөөлөгч түүний утга агуулгыг эрээ цээргүй гуйвуулж, «Хүч үл хэрэглэх тухай са-

нал нь ард түмнийг мэхлэх, хуурах зорилготой», «хүч үл хэрэглэхийн хууль зүйн үр дагавар гэгчийг энд дахин ярих шаардлагагүй» гэх мэтээр саад хийхийг оролдож байв.

НҮБ-ын Дүрмийн тусгай хорооны илтгэлээр хэлсэн үгэндээ «империализм, колоницлол, жанжлалын эсрэг тэмцэлд «гуравдахь ертөнц» гол тулгуур хүчин боллоо. Тэд НҮБ-д олонхи нь болсон бөгөөд үүрэг роль нь улам өсч байна. Гэтэл энэ бодит байдлыг НҮБ-ын Дүрэм бүрэн тусгаж чадахгүй байна»¹ хэмээн ярьж НҮБ-ын Дүрмийг хянаж үзэхийг Хятадын төлөөлөгч эрэлхийлж байгаа юм.

«Хятадын төлөөлөгч НҮБ-ын санхүү төсвийн асуудлаар ч гэсэн «хоёр хэт их гүрний» тухай томъёоллоо баримталж «НҮБ-ын санхүүгийн бэрхшээл нь Дүрмийн зорилго, зарчмуудыг зөрчиж байгаа нэг буюу хоёр хэт их гүрний зальт ажиллагаатай холбоотой учир хариуцлагыг тэд хүлээх ёстой»¹ гэж ярьж байна.

1979 оны 9-р сард эхлэсэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXXIV чуулганд хятадын төлөөлөгчдийн оролцож байгаа байдлаас үзэхэд хятадын гадаад бодлогын социализмын эсрэг, ЗХУ-ын эсрэг агуулга нь улам л гаарч байна.

Тус чуулганы ерөнхий шүүмжлэлийн үеэр хятадын төлөөлөгч үг хэлэхдээ, ЗХУ-ыг урьдын адил бүх асуудалд хамруулан элдвээр гүтгэж, «гурав дахь ертөнцийн» орнуудыг түүний эсрэг тухирч байлаа. Мөн хятадын эрх баригчдаас Социалист Вьетнамын эсрэг хийсэн ялт түрэмгийллийг элдвээр цагаатгаж, Зүүн Өмнөд Азийн орнуудыг Вьетнамын эсрэг тухирч байв. Хятадын төлөөлөгчид өнөө үеийн хамгийн зангилаа асуудал болох энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг зогсоож, зэвсэг хураах талаар аанай л сөрөг байр суурь эзэлж байгаа нь илт байна.

Олон улсын харилцаанд жанжлах бодлого гаргуулахгүй байх тухай асуудлыг Ерөнхий Ассамблейд хэлэлцүүлэх тухай ЗХУ-ын маш чухал санаачлагад Хятадын төлөөлөгчид эмзэглэн цочиж, уг асуудалд ихээхэн дургүйцэж байгаа нь Бээжингийн эрх баригчдаас явуулж буй жанжлах бодлоготой нь шууд холбоотой юм.

Дээр өгүүлсэн бүхнээс үзэхэд БНХАУ-ын эрхийг НҮБ-д сэргээснээс хойш эдүүгээ хүртэл Хятадын удирдах бүлэг нэг ч нааштай санаачлага гаргаагүйгээр барахгүй дэлхийн социалист систем, олон улсын коммунист ажилчны болон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, энх тайван, бүх нийтийн аюулгүй байдлын үйлсэд өширхөн дайсагнасан Маогийн их гүрний дээрэнгүй чиг шугамыг баримталсаар байна. Тэд өнөөгийн олон улсын байдал, түүнд нөлөөлөх гол хүчин зүйлийг үнэлэхдээ пролетарийн ангич хандлагыг аль хэдийн таягдан хаяад юуны өмнө ЗХУ тэргүүтэй социалист хамтын нөхөрлөлийн орнуудыг гүтгэн дайрах, энх тайванч гадаад бодлогыг нь мушгин гуйвуулах, тэдний аливаа санаачлагыг эсэргүүцэх, их гүрний дээрэнгүй жанжлах бодлогоо сурталчлах, империализмыг эсэргүүцэгч дэвшилт хүчний дотор хагарал гаргах, «гуравдахь ертөнцийн» орнуудын дунд жанжлах байр суурь олж авах, империалист хамгийн харгис хүчнүүдтэй эвсэл холбоогоо зузаатгахад НҮБ-ыг ашиглахыг эрмэлзэж байгаа нь илт харагдаж байна. Ялангуяа Зөвлөлтийг дайсагнасан үйл ажиллагаа нь сүүлийн үед улам гаарч, ЗХУ-д «социал-империализм» гэдэг хаяг зүүж, ЗХУ-ын энх тайванч гадаад бодлогын бүх чиглэлийг гүтгэн дайрч, түүний эсрэг «өргөн фронт» байгуулахыг санаархаж байна.

БНХАУ-ын төлөөлөгчдөөс НҮБ-д явуулж буй дипломат үйл ажиллагаа нь нэгэнт НҮБ-ын эрхэм зорилго, чухал зарчмуудад харшилж бай-

гаа учир даян дэлхийн энх тайван, улс түмний аюулгүй байдал, түүний дотор хятадын олон зуун сая ард түмний өөрсдийнх нь эрх ашигт ноцтой хор уршиг учруулж байна.

Ю. Цэрмаа

КИТАЙСКАЯ ДИПЛОМАТИЯ В ООН

Р е з ю м е

Автор статьи, на основе документов и материалов сессий Генеральной Ассамблеи ООН, анализирует китайскую дипломатию в ООН.

Как известно, в течении 22 лет КНР не могла восстановить свои права в ООН. И только благодаря усилиям Советского Союза и других стран социалистического содружества, направленным на восстановление права Китая в ООН и на изгнание из нее чанкайшистов, а также с помощью поддержки других стран, Китаю удалось занять свое право в ООН. Народы, мира, в том числе и монгольский народ, надеялись, что Китай, восстановив право в ООН, став постоянным членом Совета Безопасности, будет активно бороться за укрепление мира и развитие международного сотрудничества, за расширение антиимпериалистического фронта против колониализма и агрессии, что он внесет позитивный вклад в деятельность этой организации. Однако, подчеркивает автор, надежды народов и стран, активно борющихся за принятие КНР в ООН, не оправдались. Дело в том, что Китай стал использовать трибуну Генеральной Ассамблеи ООН для осуществления своего внешнеполитического курса, прямо противоречащего делу укрепления всеобщего мира и безопасности народов. Автор особо отмечает, что главная деятельность китайских представителей в ООН направлена, прежде всего, на разжигание антисоветизма, особенно у стран «третьего мира». Для этого китайские представители, используя трибуну ООН, широко пропагандируют свою реакционную, антимарксистскую теорию «трех миров».

В статье подчеркивается, что китайские представители с момента восстановления права в ООН злобно выступали против всех предложений Советского Союза и других социалистических стран направленных на сохранение мира и укрепление всеобщей безопасности, на разоружение и прекращение гонки вооружения, на предотвращение новой войны.

В заключение автор отмечает, что Китай за всю свою деятельность в ООН не только не внес ни одного позитивного предложения, а, наоборот, используя эту всемирную организацию, проводит маоистскую великодержавную, гегемонистскую политику, направленную против мировой системы социализма, международного коммунистического и рабочего движения, против национально-освободительного движения, против мира и всеобщей безопасности.